

## **ЯПОН, ОРОСЫН ГАЗАР НУТГИЙН МАРГААНТАЙ АСУУДАЛ БА ОХУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ В.ПУТИНЫ 2005 ОНЫ АЙЛЧЛАЛ**

*Т.Амгалан\**

Япон, Орос нь 1885 онд анх дипломат харилцаа тогтоосноос хойш олон улсын харилцаанд гарч байсан өөрчлөлтүүдээс улбаалан хоёр улсын харилцаанд энх тайван, дайны байдал үргэлжилж ирсэн бөгөөд олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоо задран унасан 1990-ээд оны эхээр Япон, Оросын харилцаа шинэ түвшинд гарч ирсэн юм. Улмаар хоёр улсын харилцаа 2003 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, Японы Засгийн газрын тэргүүн Ж.Коизүми нарын баталсан “Япон-Оросын хамтын ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу худалдаа, эдийн засаг, батлан хамгаалах зэрэг салбарт тодорхой хэмжээгээр хөгжиж байна.

Япон, Орос нь бүс нутгийн их гүрнүүд, “Их 8”-ын гишүүн орнууд болохын хувьд олон улсын болон бүс нутгийн хэмжээний хүндрэлтэй асуудлуудад хамтдаа хариуцлага хүлээдэг, шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг зэрэгтэй холбоотойгоор Японы гадаад улс төрийн бодлого дахь Оросын чиглэл улам бүр чухал үүрэгтэй болж ирж байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины энэ удаагийн Япон улсад хийх албан ёсны айлчлалын тов Шотландын Гленийгл хотод болсон “их 8”-ын уулзалтын үеэр гарсан юм. Энэ айлчлал нь В.Путины 2000 оны 9-р сараас хойш Япон улсад хийж буй анхны айлчлал бөгөөд энэ айлчлалаар хэлэлцэх хамгийн гол асуудлуудын нэг нь хоёр улсын хувьд дэлхийн II дайныг албан ёсоор дуусгах энх тайвны гэрээнд гарын үсэг зурахаас татгалзахад хүргэж буй 4 аралтай холбоотой газар нутгийн маргаантай асуудал юм.

Эдгээр арлууд нь 1855 онд Хаант Орос улс, Токугавагийн Засгийн газрын хооронд байгуулсан Япон-Оросын Найрсаг харилцааны гэрээний дагуу бол Японы газар нутаг байсан бөгөөд дэлхийн II дайнд Япон бууж өгсөнөөс 3 хоногийн дараа ЗХУ-ын цэргүүд эзэлж авсан юм. Үүний дараа Японы 17000 иргэн тэндээс дүрвэн гарсан бөгөөд эдгээр арлууд нь одоог хүртэл ОХУ-ын мэдэлд байгаа юм.

Үүний зэрэгцээ энэ айлчлал нь хоёр улс албан ёсны дипломат харилцаа тогтоосны 150 жилийн ойтой давхцаж байгаа бөгөөд Японы тал үүнийг нь газар нутгийн маргаантай асуудлыг шийдвэрлэхэд нааштай алхам болно гэдэгт найдаж байсан бөгөөд үнд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины “ОХУ нь Япон улсыг оролцуулаад бүх хөрш улсуудтайгаа газар

нутгийн болон бусад маргаантай асуудлуудаа шийдвэрлэхийг хүсч байна”<sup>1</sup> гэж мэдэгдсэн нь нөлөөлсөн болов уу. Ийм ч учраас энэ айлчлалыг амжилттай болгох тал дээр аль аль тал нь ялангуяа Японы тал ихээхэн чармайлт гаргаж, хоёр улсын Гадаад хэргийн сайд нар айлчлалын бэлтгэл ажил, хэлэлцэх асуудлын талаар уулзаж ярилцсан байна.

Гэхдээ олон орны судлаач, ажиглагч нар газар нутгийн маргаантай асуудал дээр хоёр талын байр суурь ямар нэгэн онцгой зөвшилцөлд хүрнэ гэхэд хэт хол байна гэж үзэж байсан юм. Учир нь айлчлалын өмнө ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2005 оны 9 сарын 27-нд “Москва нь Оросын хяналтанд байгаа арлуудыг Японы талд найр тавин өгөх асуудлыг хэлэлцэхэд бэлэн биш байна”<sup>2</sup> гэж мэдэгдсэн, мөн Оросын телевизийн шууд нэвтрүүлэгт оролцож байхдаа “Курилын эдгээр 4 арал бол Оросын мэдэлд оршиж байгаа бөгөөд энэ нь олон улсын эрх зүйгээр зохицуулагдсан асуудал юм. Энэ нь дэлхийн II дайны шууд үр дүн мөн бөгөөд бид энэ талаар ямар нэгэн гэрээ, хэлэлцээр хийх төлөвлөгөөгүй байна”<sup>3</sup> гэж мэдэгдсэн болон В.Путины шадар туслах С.Э.Приходко “Хоёр улсын тэргүүлэгчдийн баталсан бүх хуучин бичиг, баримтуудын хүчинтэйг хүлээн зөвшөөрч байна. Иймд хуучин гэрээ, зөвшилцөлүүдийг зохицуулах шинэ баримт бий болгох шаардлага алга”<sup>4</sup> гэсэн тайлбар зэргээс үзвэл Оросын тал газар нутгийн маргаантай асуудалд ямар ч байсан буулт хийх сонирхолгүй байгаа нь харагдаж байсан бөгөөд Японы тал ч үүнийг ойлгосон болов уу. Учир нь айлчлалаас өмнө Японы ГЯЯ-ны сайд Таро Асо, ОХУ-ын ГЯЯ-ны сайд С.Лавровтай уулзахдаа мөн “В.Путины Японд хийх айлчлалын үеэр арлуудтай холбоотой газар нутгийн маргаантай асуудлыг шийдвэрлэнэ гэхэд хэцүү юм”<sup>5</sup> хэмээн мэдэгдэж байжээ.

Хэдийгээр энх тайвны гэрээнд гарын үсэг зурсаны дараа Шикотан, Хабомай арлуудыг буцааж өгөхөөр тохирсон заалт ЗХУ-Японы 1956 оны гэрээнд байгаа, ОХУ үүний дагуу дээрхи маргаанаа шийдвэрлэхийг зорьж байгаа ч Японы тал татгалзсан хариу өгсөөр байгаа юм. Японы Засгийн газрын төлөөлөгч Хироюки Хосода “Япон улс анхнаасаа л 4 арлыг бүгдийг нь буцааж өгөхийг шаардаж байсан юм”<sup>6</sup> гэж мэдэгдсэн байна. Гэхдээ Японы тал Эрхүүгийн уулзалтын үеэр эхний ээлжинд 4 арлын хоёрыг нь буцааж өгөх арга замыг нэгэн үе сайшааж байсан нь Оросын талд Япон нь хоёр арлаа буцааж авсанаар асуудлыг шийдэж болох юм байна гэдэг буруу ойлголт төрүүлсэн байж болох талтай юм.

Японы Ерөнхий сайд Ж.Коизүми нь газар нутгийн маргаантай асуудлаар ялалт байгуулах явдалд дотоодын маш их дарамт, шахалтанд байгаа бөгөөд дээрхи арлууд дээр амьдарч байсан хүмүүс болон тэдний үр сад нэгдэн нийгэмлэг байгуулж, засгийн газартаа шахалт үзүүлж байна. Тэдний зарим нь эхний ээлжинд хоёр арлыг нь ч болов буцааж

авах хэрэгтэй, тэгсэн тохиолдолд загасчид Оросын талд төлбөр төлөхгүй байна хэмээн шаардаж байгаа юм.

Үүнээс гадна албан ёсоор хэзээ ч зарлагдаж байгаагүй хэрнээ олон нийтэд өргөн тархсан асуудлыг шийдэх гэсэн Японы нэг санаачлага нь маргаантай арлуудын нэг Эторофу болон маргааны субъект биш Оросын арал Уруппугийн хооронд хилийн шугам татах явдал бөгөөд ингэж чадвал үр дүнд нь маргаантай 4 арал Японы газар нутагт багтах юм.

Японы зүгээс асуудлыг нааштай шийдвэрлэхэд дөхөм болно гэж үзэж байсан нэг зүйл нь Оросод үзүүлэх эдийн засгийн тусламж, зээл, хөрөнгө оруулалт байсан бөгөөд анх Япон нь 4 арлаа буцааж авахаас нааш ОХУ-тай эдийн засгийн харилцаа, холбоо хөгжүүлэхгүй гэсэн байр суурьтай байсан ч 1996 оноос уг байр сууриа өөрчилсөн юм. Гэсэн ч сүүлийн жилүүдийн нефтийн үнийн огцом өсөлтөөс болж ОХУ-ын эдийн засаг тодорхой хэмжээнд амжилттай хөгжих болсоноор Японы хувьд энэ тал дээр найдвар муутай болсон юм. Харин одоогийн байдлаар харин ч бүр эсрэгээрээ Оросын газрын тосонд хүрэх нь Японы хувьд чухал асуудлуудын нэг болоод байна. Япон өөрийн газрын тосыг бараг бүгдийг нь гаднаас импортоор авдаг учир Алс Дорнодод газрын тосны эх үүсвэртэй болох юм бол тэдний хувьд их чухал алхам болох юм. ОХУ-ын хувьд ч Алс Дорнодын бүс нутгийг хөгжүүлэхэд гадны санхүүжүүлэлт их чухал байгаа бөгөөд тэдний хувьд Оросын эдийн засаг Японы тусламж, дэмжлэгээс хараат биш болсон ч Япон нь хамгийн боломжит түншүүдийн нэг болж байгаа аж. Үүний нэг нотолгоо нь В.Путины айлчлалыг Оросын 100 гаруй бизнес, санхүүгийн бүлэглэлийн төлөөлөгчид дагалдаж ирсэн бөгөөд Токио зочид буудалд болсон уулзалтан дээр В.Путин эдийн засгийн уялдаа холбоогоо бэхжүүлэх шаардлагыг чухалчилж “Японы шууд хөрөнгө оруулалт бусад улсуудын хөрөнгө оруулалттай харьцуулахад маш бага буюу гадаадын нийт хөрөнгө оруулалтын дөнгөж 1 хувийг эзэлж байна. Энэ нь өнөөгийн нөхцөл байдалд хоёр улсын эдийн засгийн хүчин чадалтай нийцэхгүй байна”<sup>7</sup> гэж мэдэгджээ. Ийм учраас газар нутгийн маргаантай асуудлыг нааштай шийдвэрлэхэд эдийн засгийн давуу талаа ашиглана гэдэг аль аль талд нь ашиг багатай байх нь ойлгомжтой юм.

2005 оны 11 сарын 21-нд болсон дээд хэмжээний уулзалтын үеэр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, Японы Ерөнхий сайд Ж.Коизүми нар Оросын мэдэлд байгаа арлуудын талаархи удаан үргэлжилж буй асуудал дээр ямар ч ахиц, дэвшилд хүрч чадаагүй бөгөөд харин терроризмтэй тэмцэх, худалдаа, эдийн засаг, аюулгүй байдлын тал дээр хамтран ажиллана гэсэн тохиролцоонд хүрч, сайд нар нь олон улсын

терроризмээс эхлээд Оросын Зүүн Сибирээс Алс Дорнод хүртэл нефть дамжуулах хоолой тавих, эрчим хүчний асуудал болон бусад асуудлыг хамарсан хамтын ажиллагааны хүрээг нарийвчилсан 12 баримт бичигт<sup>8</sup> гарын үсэг зургаасан байна. Уулзалтын дараа В.Путин, Ж.Коизүми болон бусад сайдууд Оросын ДХБ-д элсэн орохыг сайшааж, мэдээллийн технологи, гэмт хэргийн мөрдлөг, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тал дээр хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээ, хэлэлцээрт<sup>9</sup> гарын үсэг зурсан боловч мэдээж тэдний хувьд хамгийн гол нь газар нутгийн маргаантай асуудлаа шийдвэрлэх явдал байсан хэдий ч судлаач, ажиглагч нарын урьдчилан тооцоолж байсанчилан тохиролцоонд хүрч чадаагүй, мөн үзэл бодлын ялгаа ихтэй, нэгдсэн байр сууринд хүрэх болоогүй байгаа нь ажиглагдсан бөгөөд уулзалтын эцэст “Бид хоёр талын харилцааны хөгжлийн зөрчилдөөнийг даван гарч өнгөрсөн гэрээ хэлэлцээр, бичиг баримтан дээр үндэслэн хоёр улс хоёул хүлээн авч чадах шийдвэрийг эрэлхийлэх болно гэдэг нэгдсэн байр сууринд хүрлээ”<sup>10</sup> гэдэг ерөнхий мэдэгдэл гарчээ. Гэхдээ айлчлалын үеэр хүрсэн нэг нааштай зүйл нь хоёр талаас өөрсдийн ашиг сонирхол, дээрхи 4 арал дээр амьдарч буй хүмүүсийн ашиг сонирхолд нийцсэн, эдийн засгийн төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсон явдал юм.

Энэ удаагийн айлчлалаас үзэхэд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины айлчлал урьдын адил Япончуудын хүсэн хүлээж байсан үр дүнд хүрч чадаагүй бөгөөд Японы Ерөнхий сайд Ж.Коизүми түүний өмнөх сайдуудын нэгэн адил Кунашири, Эторофу, Шикотан, Хабомай арлуудыг Оросоос буцаан авч чадсангүй.

### ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. [www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20050928a9.htm](http://www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20050928a9.htm)
2. [www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?eo20051129kn.htm](http://www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?eo20051129kn.htm)
3. [www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20050928a9.htm](http://www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20050928a9.htm)
4. [www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20051117a5.htm](http://www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20051117a5.htm)
5. [www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20051117a5.htm](http://www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20051117a5.htm)
6. [www.keralanext.com/news/?id=217640](http://www.keralanext.com/news/?id=217640)
7. [www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20051122a1.htm](http://www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20051122a1.htm)
8. [www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?eo20051129kn.htm](http://www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?eo20051129kn.htm)
9. [www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20051122a1.htm](http://www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20051122a1.htm)
10. [www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20051122a1.htm](http://www.japantimes.co.jp/cgi-bin/getarticle.pl5?nn20051122a1.htm)